



МОНГОЛ УЛС
ХЭНГИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2017 оны 04 сарын 04 өдөр

Дугаар А/140

Хэрлэн сум

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Төсвийн тухай хуулийн 58 дугаар зүйлийн 58.2.17, Засгийн газрын 2016 оны 202 дугаар тогтоолоор батлагдсан "Улсын аварга малчин шалгаруулах тухай журам"-ын 4 дүгээр хэсгийн 12 дахь заалт, Сангийн сайдын 2012 оны 239 дүгээр тушаалаар батлагдсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2 дугаар зүйлийн 2.1.3 дахь заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Мал аж ахуйн үйлдвэр, үр ашгийг нэмэгдүүлж, мал маллагааны уламжлалт аргыг эзэмшин мал сүргийнхээ тоо толгойг өсгөн "Улсын аварга малчин" цол тэмдэг гардан авсан малчдын шагнал улаан халз бүхий 5 ханатай гэрийг тээвэрлэж ирэх болсонтой холбогдуулан хөрөнгө зарцуулсугай.

2. Дээрх зардалд шаардагдах 250000 /хоёр зуун тавин мянган/ төгрөгийг Засаг даргын нөөц сангийн болзошгүй зардлаас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /С.Нямдаваа/-д зөвшөөрсүгэй.

3. Зардлын гүйцэтгэлд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга /Ж.Ганбаатар/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Н.ГАНБЯМБА

01 685